



МОНГОЛ УЛС
ДУНГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 11/НЗ

Мандалговь

Г Хурдан морины уралдааныг
хориглох тухай Г

Монгол Улсын засгийн газрын 2008 оны 305 дугаар тогтоолын хавсралт “Малын гоц халдварт өвчний оношийг баталгаажуулах, хорио цээр, хязгаарлалтын бүс тогтоох уг бүсэд үйл ажиллагаа явуулах журам”-ын 23.2 дугаар заалт, Засгийн газрын 2005 оны 119 дүгээр тогтоолын 3 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Эрдэнэдалай, Адаацаг, Баянжаргалан, Цагаандэлгэр, Говь-Угтаал, Дэрэн, Дэлгэрцогт сумдын нутагт Малын гоц халдварт хонины цэцэг өвчин гарч хорио цээр хязгаарлалтын дэглэм тогтоосон тул аймгийн нийт нутаг дэвсгэрт “Мандлын хурд” бүсийн уралдаанаас бусад бүх хурдан морины уралдааныг 5 дугаар сарын 01 хүртэлх хугацаанд зохион байгуулахыг хориглосугай.

Хоёр. Захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг ХХААГ-ын дарга Б.Мөнхжаргал, Мэргэжлийн хяналтын газрын дарга Ш.Төрбат, Сумдын засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

020000110

